**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2026/116/НА-СА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг

2026 он


Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Батцогт Утас: 89008258
Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn

Аудитын менежр: Ж.Энхцоодол Утас: 7034-2580
Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид
Утас: 9511-2689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Ахлах аудитор Ш.Ганчимэг Утас: 9937-7360
Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24. № 188

танай ____________ны № ____________т

БАЯННУУР СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ЭНХНАРАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын 8.4 дэх заалтад "Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 316.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд дээрх тогтоолын 7.7.2-т заасныг үндэслэн сургалтын тоног төхөөрмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж "Мэксим консалтинг" ХХК-тай 48 сарын хугацаатай гэрээ байгуулан авснаар 75.0 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

6326050197

**Бусад асуудлын хэсэг**

Баяннуур сумын Цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 71 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 88.9 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **170,300,816.58** | **102,264,317.35** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **131,531,734.78** | **40,314,048.14** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **131,531,734.78** | **40,314,048.14** |
| **3122** | **Гадаад валют** | **131,531,734.78** | **40,314,048.14** |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 131,531,734.78 | 40,314,048.14 |
| **33** | **АВЛАГА** | **316,751.80** | **7,384,139.21** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 316,751.80 | 7,384,139.21 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **38,452,330.00** | **54,566,130.00** |
| **351** | **Түүхий эд материал** | **19,990,750.00** | **27,605,450.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 19,990,750.00 | 27,605,450.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **18,461,580.00** | **26,960,680.00** |
| 35420 | Аж ахуйн материал | 10,110,400.00 | 8,780,400.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,351,180.00 | 18,180,280.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **362,938,531.79** | **351,081,079.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **362,938,531.79** | **351,081,079.31** |
| **392** | **Биет хөрөнгө** | **352,476,531.79** | **340,956,579.31** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 370,368,233.00 | 370,368,233.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (90,313,452.15) | (106,416,418.83) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 62,535,624.92 | 76,638,524.92 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (36,308,003.85) | (43,033,801.76) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,161,045.00 | 23,324,945.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,718,191.41) | (6,604,068.14) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 34,712,486.00 | 34,712,486.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,961,209.72) | (8,033,320.88) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **10,462,000.00** | **10,124,500.00** |
| 39301 | Програм хангамж | 1,450,000.00 | 1,450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (337,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,012,000.00 | 9,012,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **533,239,348.37** | **453,345,396.66** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **914,600.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | **914,600.00** |
| **413** | **Өглөг** | - | **914,600.00** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 914,600.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **533,239,348.37** | **452,430,796.66** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **533,239,348.37** | **452,430,796.66** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 89,253,789.00 | 89,253,789.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 9,012,000.00 | 9,012,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **165,077,346.74** | **84,268,795.03** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 165,077,346.74 | 165,077,346.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (80,808,551.71) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 278,908,212.63 | 278,908,212.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **533,239,348.37** | **453,345,396.66** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **651,194,900.00** | **657,200,419.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **17,895,619.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | **17,895,619.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | **17,895,619.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,595,619.00 |
| 1200044 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө | | 14,273,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал | | 2,027,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **651,194,900.00** | **639,304,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **602,594,900.00** | **587,804,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 533,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 602,594,900.00 | 587,271,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **48,600,000.00** | **51,500,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,600,000.00 | 51,500,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **606,847,577.92** | **738,008,970.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **606,847,577.92** | **738,008,970.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **606,444,886.93** | **737,112,920.71** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **400,260,338.85** | **527,426,433.05** |
| 210101 | Үндсэн цалин | 269,072,570.34 | 336,533,598.49 |
| 210102 | Нэмэгдэл | 125,065,568.97 | 154,155,952.45 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 14,445,706.16 |
| 210104 | Урамшуулал | 6,122,199.54 | 22,291,175.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **48,440,383.44** | **56,622,775.18** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,069,006.60 | 38,503,727.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,804,483.43 | 4,529,861.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,903,741.25 | 2,264,731.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,901,513.25 | 2,264,731.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,761,638.91 | 9,059,723.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **47,045,309.01** | **44,500,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,257,309.01 | 7,224,165.25 |
| 210302 | Түлш, халаалт | 42,788,000.00 | 37,075,834.75 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 200,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **55,959,990.00** | **56,295,360.00** |
| 210502 | Хоол, хүнс | 55,959,990.00 | 56,295,360.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,152,000.00** | **4,893,950.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,152,000.00 | 4,893,950.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **782,100.00** | **1,865,900.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 782,100.00 | 1,865,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **52,804,765.63** | **45,508,502.48** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,975,378.15 | 14,987,350.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 749,600.00 | 2,396,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28,079,787.48 | 28,124,252.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **402,690.99** | **896,050.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **402,690.99** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 402,690.99 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | **896,050.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 896,050.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **44,347,322.08** | **(80,808,551.71)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **44,347,322.08** | **(80,808,551.71)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **651,194,900.00** | **640,900,419.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **1,595,619.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | **1,595,619.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | **1,595,619.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,595,619.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **651,194,900.00** | **639,304,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **602,594,900.00** | **587,804,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 533,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 602,594,900.00 | 587,271,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **48,600,000.00** | **51,500,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,600,000.00 | 51,500,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **570,399,529.09** | **730,124,905.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **570,399,529.09** | **730,124,905.64** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **569,996,838.10** | **729,228,855.64** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **398,173,597.50** | **529,039,445.64** |
| 210101 | Үндсэн цалин | 266,985,828.99 | 331,131,894.44 |
| 210102 | Нэмэгдэл | 125,065,568.97 | 161,170,669.09 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 14,445,706.16 |
| 210104 | Урамшуулал | 6,122,199.54 | 22,291,175.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **48,440,383.44** | **62,227,150.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,069,006.60 | 42,318,198.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,804,483.43 | 4,978,988.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,903,741.25 | 2,490,294.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,901,513.25 | 2,490,294.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,761,638.91 | 9,949,376.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **47,045,309.01** | **44,500,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,257,309.01 | 7,880,098.34 |
| 210302 | Түлш, халаалт | 42,788,000.00 | 36,419,901.66 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 200,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **49,997,720.00** | **65,209,860.00** |
| 210502 | Хоол, хүнс | 49,997,720.00 | 65,209,860.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,152,000.00** | **6,103,950.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,152,000.00 | 6,103,950.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **782,100.00** | **3,148,600.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 782,100.00 | 3,148,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **24,405,728.15** | **18,999,850.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,607,328.15 | 13,763,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,798,400.00 | 5,236,450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **402,690.99** | **896,050.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **402,690.99** | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 402,690.99 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | **896,050.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 896,050.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **80,795,370.91** | **(89,224,486.64)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,690,000.00** | **1,993,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,690,000.00** | **1,993,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **5,690,000.00** | **1,993,200.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 5,690,000.00 | 1,993,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(5,690,000.00)** | **(1,993,200.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **75,105,370.91** | **(91,217,686.64)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **131,531,734.78** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **131,531,734.78** | **40,314,048.14** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **89,253,789.00** | **278,908,212.63** | **165,077,346.74** | **533,239,348.37** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (80,808,551.71) | (80,808,551.71) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **89,253,789.00** | **278,908,212.63** | **84,268,795.03** | **452,430,796.66** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | Дүн | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **680,623,300.00** | **731,222,055.64** | **(50,598,755.64)** | **107.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **680,623,300.00** | **729,228,855.64** | **(48,605,555.64)** | **107.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **680,623,300.00** | **729,228,855.64** | **(48,605,555.64)** | **107.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **542,700,400.00** | **529,039,445.64** | **13,660,954.36** | **97.5** |
| 210101 | Үндсэн цалин | 343,638,700.00 | 331,131,894.44 | 12,506,805.56 | 96.4 |
| 210102 | Нэмэгдэл | 188,500,900.00 | 161,170,669.09 | 27,330,230.91 | 85.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 14,445,706.16 | (14,445,706.16) | |
| 210104 | Урамшуулал | 10,560,800.00 | 22,291,175.95 | (11,730,375.95) | 211.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **67,512,000.00** | **62,227,150.00** | **5,284,850.00** | **92.2** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,803,800.00 | 42,318,198.00 | 3,485,602.00 | 92.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,427,000.00 | 4,978,988.00 | 448,012.00 | 91.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,713,600.00 | 2,490,294.00 | 223,306.00 | 91.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,713,600.00 | 2,490,294.00 | 223,306.00 | 91.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,854,000.00 | 9,949,376.00 | 904,624.00 | 91.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | **44,500,000.00** | **(44,500,000.00)** | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 7,880,098.34 | (7,880,098.34) | |
| 210302 | Түлш, халаалт | - | 36,419,901.66 | (36,419,901.66) | |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 200,000.00 | (200,000.00) | |
| **2105** | **Норматив зардал** | **46,769,700.00** | **65,209,860.00** | **(18,440,160.00)** | **139.4** |
| 210502 | Хоол, хүнс | 46,769,700.00 | 65,209,860.00 | (18,440,160.00) | 139.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | **6,103,950.00** | **(6,103,950.00)** | |
| 210604 | Урсгал засвар | - | 6,103,950.00 | (6,103,950.00) | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,152,000.00** | **3,148,600.00** | **3,400.00** | **99.9** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,152,000.00 | 3,148,600.00 | 3,400.00 | 99.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,489,200.00** | **18,999,850.00** | **1,489,350.00** | **92.7** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,349,900.00 | 13,763,400.00 | 1,586,500.00 | 89.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,139,300.00 | 5,236,450.00 | (97,150.00) | 101.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **1,993,200.00** | **(1,993,200.00)** | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | **1,993,200.00** | **(1,993,200.00)** | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 1,993,200.00 | (1,993,200.00) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **639,304,800.00** | **(639,304,800.00)** | |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | **587,804,800.00** | **(587,804,800.00)** | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 533,300.00 | (533,300.00) | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 587,271,500.00 | (587,271,500.00) | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | **51,500,000.00** | **(51,500,000.00)** | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | 51,500,000.00 | (51,500,000.00) | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **131,531,734.78** | **(131,531,734.78)** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **40,314,048.14** | **(40,314,048.14)** | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,749.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,644.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 451.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 654.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

1. Ажилтны ээлжийн амралтын хугацаанд цалин хөлс давхардуулан 431.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг тус тус зөрчсөн тул Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3 заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

1. Цэцэрлэгийн эрхлэгч Д.Энхнаранд  аймгийн Боловсролын газрын даргын 2025.10.08-ны өдрийн А/104 дүгээр тушаалыг үндэслэн батлагдаагүй орон тооны ХАБ-ын ажлыг хавсран гүйцэтгүүлж 40 хувийн нэмэгдэл хөлсөнд 654.8 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В-д заасантай тус тус нийцэхгүй байгаа тул Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д заасныг үндэслэн албан шаардлага өгсөн.

### 5.3 Зөвлөмж

1. *<u>Илрүүлэлт:</u>*

Аж ахуйн нэгж байгууллагаас хүүхдийн хоол хүнсний хэрэгцээнд бараа, материал  бэлтгэн нийлүүлэхээр ирүүлсэн үнийн саналын баримт бичиг нь худалдан авах ажиллагааны бүтээгдэхүүний чанар техникийн шаардлагад бүрэн нийцээгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

ТБОНХБАУХАТ хуулийн 6-р бүлэг, БШУСайдын 2024 оны 3-р сарын 20-ны А/140 дүгээр тушаалын хавсралт "Сургалтын байгууллагын хүүхдийн хоол хүнсний хангамж үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс | | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| НДШ-ийн авлага тайланд тусгаагүй. | 1 | 7,067.4 | 1 | 7,067.4 | | 1 | 7,067.4 | | | | | |
| няравын тайлангийн бараа материалын үлдэгдэл тайлангийн үлдэгдэлтэй зөрсөн. | 1 | 2,576.6 | | | 1 2,576.6 | 1 | 2,576.6 | | | | | |
| Дүн | 2 | 9,644.0 | 1 | 7,067.4 | 1 2,576.6 | 2 | 9,644.0 | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ээлжийн амралтын хугацаанд цалин тооцож олгосон. | 1 | 451.1 | 1 | 451.1 | | | | | | | | |
| Цэцэрлэгийн эрхлэгч Д.Энхнаранд батлагдаагүй орон тооны ХАБ-ын ажилтны хавсран ажилласны 40 хувийн нэмэгдэл хөлс олгосон. | 1 | 654.8 | | | 1 | 654.8 | | | | | | |
| Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой зөрчил | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 3 | 1,105.9 | 1 | 451.1 | 1 | 654.8 | 1 | 0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээлэл хоцроосон. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | - | - | - | - | 1 | 0 |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил  Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

## ААБ 8.8: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ /эцсийн аудит/

Байгууллагын нэр:Баяннуур сумын цэцэрлэг

Аудитын код: БУА-2026/97/НА-СТА-ТШЗ

Байгууллагын РД: 9012281

Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаа: 2025.01.01-2025.12.31

Хүснэгт А. Эрсдэлтэй АГАДҮТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

| дд | АГАДҮТ | АГАДҮТ-ын дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт: Стандарт заалт | Шалгуур үзүүлэлт: Хууль тогтоомжийн заалт | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | МХ | Эзлэхийн амралтын хугацаанд цалин хэлс давхардуулан олгосон. | 451,070.00 | Материаллаг | Тийм | УСНББОУС 1 | Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх, зарцуулах, НББ-ийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл | Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Төлбөрийн акт тогтоох | Байхгүй | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох |
| 2 | | МХ | Цэцэрлэгийн эрхлэгч Д.Энхнаранд аймгийн Боловсролын газрын 2025.10.08-ны өдрийн А/104 дугаар тушаалыг үндэслэн батлагдаагүй орон тоо ХАБ-ын ажилтны хавсран ажилласны 40 хувийн нэмэгдэл хэлс олгосон. | 654,800.00 | Материаллаг | Тийм | УСНББОУС 1 | Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх, зарцуулах, Булган аймгийн боловсролын газрын 2025.11.04-ний өдрийн А/114 дугаар тушаалаар 2025.10.08-ны А/104 дугаар тушаалыг хүчингүй болгосон. | Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Албан шаардлага өгөх | Байхгүй | Албан шаардлага өгөх | Албан шаардлага өгөх |
| 3 | | | Гэрээ шууд байгуулах аргаар худалдан худалдан авах ажиллагааны нэгж байгууллагаас ирүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнийн саналын тоо хэмжээ, үнийн дүн засвартай, хууль журамд заасан шаардлагад нийцээгүй. | 0.00 | Материаллаг бус | Үгүй | УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар бүлэг Худалдан авах ажиллагааны удирдлага, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/257 дугаар тушаалын 1-р хавсралт 1.1-д " ТБОНӨХБАҮХ авах тухай хуулийн 35-р зүйлд заасан гэрээ шууд байгуулах аргын дагуу аж ахуй эрхлэгчтэй хэлэлцээ хийхэд энэ дэг, түүнд нийцүүлсэн захиалагчийн шийдвэрт үндэслэн зохион байгуулна. | Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Зөвлөмж өгөх | Байхгүй | Зөвлөмж өгөх | Зөвлөмж өгөх |
| 4 | | | Шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд 3 мэдээлэл хоцроож мэдээлсэн. | 0.00 | Материаллаг бус | Үгүй | | Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.15, 6.1.6, 6.2.1, 6.4.7 | Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Зөвлөмж өгөх | Байхгүй | Зөвлөмж өгөх | Зөвлөмж өгөх |
| | | | Нийт дүн | 1,105,870.00 | | | | | | | | | |

Бэлтгэсэн: ЦЭСБ аудит ХХК-ийн ахлах аудитор Ш.Ганчимэг Огноо:

Танилцаж зөвшөөрсөн Д.Энхнаран Огноо:

Анхан шатанд хянасан:
Булган аймаг дахь ТАГ-ын аудитын менежер Н.Энхцоодол Огноо:

Хоёр дахь шатанд хянасан:
Булган аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт Огноо:

Нягтлан бодогч М.Түвшинзаяа Огноо:

6317148533
9012281

1УЗ6073 0425060076 3193269

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**ТӨЛБӨРИЙН АКТ**

2026 оны 02 дугаар сарын 24 | Дугаар 01/159 - 2020282 Буа-2026/97/НА-СТА-ТАЗ | Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяннуур сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус Цэцэрлэгийн багш ажилтнуудад ээлжийн амралтын хугацаанд 451,070.00 (дөрвөн зуун тавин нэг мянга дал) төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.2-т *"Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "*Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Илүү олгосон 451,070.00 (дөрвөн зуун тавин нэг мянга дал) төгрөгийг Булган аймгийн төрийн сангийн төсвийн орлогын Бу.Аудит-орлого (РД:9039001) MN390090100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баяннуур сумын Цэцэрлэгийн эрхлэгч (Д.Энхмаран), нягтлан бодогч (М.Түвшинзаяа) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Д.БАТЦОГТ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ж.ЭНХЦООДОЛ |
| "ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙ АУДИТОР | Ш.ГАНЧИМЭГ |

Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 410 тоот өрөө, утас-70342716

6326110523

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН**
**ШААРДЛАГА**

2026 оны 02 дугаар сарын 25 Дугаар 01/116 - 2/220282 Булган сум
Бүр-2026/97/НА-СТА-ТШ8

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяннуур сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэгийн эрхлэгч Д.Энхнаранд аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/104 дүгээр тушаалыг үндэслэн батлагдаагүй орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд 654,800.00 (зургаан зуун тавин дөрвөн мянга найман зуу) төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "*Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах*", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "*Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна*", 27.6-д "*Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална*", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "*Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1.Төсвийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх.

2.Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Булган аймгийн Баяннуур сумын Цэцэрлэгийн эрхлэгч (Д.Энхнаран), нягтлан бодогч (М.Тувшинзаяа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ
"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙ АУДИТОР Ш.ГАНЧИМЭГ

Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 410 тоот өрөө, утас-70342716

6326090366